

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 28 өргөдөл бичгээр хүлээн авч, 24 өргөдлийг шийдвэрлэж, 4 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 9 өргөдөл бичгээр хүлээн авч, 8 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлт 86.5 хувьтай байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 10 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 10 санал хүсэлт ирүүлснээс гомдол 5, санал хүсэлт 5 бүртгэж холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт шилжүүлж, 10 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 100 хувьтай байна. Үүнд: Орчны эрүүл ахуйн асуудлаар 2, хууль эрх зүйн асуудлаар 1, боловсролын асуудлаар 1, цахилгаан эрчим хүчний асуудлаар 1, орчны эрүүл ахуйн асуудлаар 2, бусад асуудлаар 3 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 10 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл, Засгийн газрын 1111 төвд 4 дүгээр сард санал хүсэлт ирээгүй болно.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 12 төрлийн үйлчилгээгээр 476 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 2874 иргэнд нийт 5 мэргэжилтэн 27 төрлийн үйлчилгээгээр 3350 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

**Аймгийн Онцгой комиссын ажлын талаар:** Аймгийн Онцгой комисс 2020 оны 4 дүгээр сард 3 удаа хуралдаж Ховд аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 22 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 3 шийдвэр, аймгийн Засаг даргын 1 захирамж, Онцгой комиссын даргын 5 тушаал, үүрэг хүргүүлэх холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

“Цэрэг татлага зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/207 дугаар захирамжийг гарган цэрэг татлагыг хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаад байна.

Аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 17 дугаар тушаалаар “Маскаа зүүцгээе” аян өрнүүлж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулав. Аяны хүрээнд орон нутгийн хэмжээнд “COVID-19” халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, ард иргэдийг маск зүүж хэвшүүлэх, хүн ам олноор цуглардаг, худалдаа үйлчилгээний газрууд болон банк санхүүгийн байгууллагууд маск зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх, иргэд олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг мэдээллийг

орон нутгийн телевиз болон авто машинд чанга яригч суурилуулан мэдээллийг иргэдэд түгээн ажиллаж байна.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын баталсан хуваарийн дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нар эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэж амны хаалтгүй гадуур явж байгаа иргэдэд хяналт тавьж, амны хаалт зүүх шаардлага тавин ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар шийдвэрээр Жаргалант, Мянгад, Манхан сумдын авто замын шалган нэвтрүүлэх товчооны үйл ажиллагааг эрчимжүүлж, зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг холбогдох байгууллагуудын дарга нарт үүрэг өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Улсын Онцгой комиссоос томилогдсон ажлын хэсэг, аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 16 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгүүд 2020 оны 04 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд МоЭнКо ХХК-ны Хөшөөтийн нүүрсний уурхай, Булган сумын Булган боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн экспортын тээвэрлэлтийг онцгой нөхцөлд зохион байгуулах бэлтгэл ажилтай газар дээр нь очиж танилцан хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Дээрх үүрэг даалгаврын биелэлтийг хангасан эсэхэд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын тээвэр /авто өргөх машин механизм/-ын хяналтын улсын ахлах байцаагч, Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч нар хяналт шалгалт хийж 21-07/036/43 дугаар дүгнэлт гарган ажиллав.

Булган сумын Булган боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн экспортын тээвэрлэлт хийдэг МоЭнКо ХХК, Эй Эл Жи Ти ХХК-ууд нь Гаалийн хяналтын талбайд жолооч нарыг 14 хоног тусгаарлах байр бэлтгэж бэлэн болгосон.

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар шийдвэрийн 4 дэх заалтаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд ариутгал халдваргүйтгэл хийх хуваарийг гаргаж журмын дагуу ариутгал халдваргүйтгэлийг 87 аж ахуй нэгж байгууллагын 68248 м<sup>2</sup>, 63 автобусын 6498 м<sup>2</sup>, 19 айл өрхийн 415 м<sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэлээ. Жаргалант сумын Засаг даргын “Хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай” 2020 оны А/125 дугаар захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж талбай, үерийн далан, суваг шуудуунд цэвэрлэгээ хийх хуваарийг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн шуурхай штаб 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хуралдаж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг спорт заал, /Ерөнхий боловсролын сургуулийн заал хамаарахгүй/ фитнес клубуудад мэргэжлийн байгууллагууд хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хангаж буй үйлчилгээний байгууллагуудыг тусгай горимоор ажиллуулах чиглэл өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын 4 дүгээр сард улсын төсвийн санхүүжилт 24397,2 сая төгрөг ирэхээс 22742,5 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж,

санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгож санхүүжүүллээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 2345,7 сая төгрөгийн санхүүжилтээс 691,0 сая төгрөгийн санхүүжилт ирж сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэгт 5284,1 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 2456,4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээс сургуульд 9903,6 сая төгрөг, цэцэрлэгт 4790,2 сая төгрөг, хүн эмнэлэгт 2045,6 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 175,6 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 184,5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Орон нутгийн төсвийн 163 байгууллага, төсөл, сангийн 38, ОНӨААТҮГ-ын 8, бусад 4 нийт 213 байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсныг хүлээн авч хянан “Е” цахим тайлангаар нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хянуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2019 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 4 дүгээр сарын 1-20-ны хооронд аймгийн Аудитын газар аудитаар баталгаажуулан “Зөрчилгүй санал” дүгнэлт өглөө.

Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг дуустал зогсоосонтой холбогдуулан сургууль, цэцэрлэг, дотуур байрны агуулахад хадгалагдаж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар хадгалах боломжгүй болсон тул хүнсний бүтээгдэхүүн гэрээгээр нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагатай харилцан тохиролцож, буцааж татан авалт хийлгэх, эсвэл худалдан борлуулах зэрэг арга хэмжээ авч, ажиллах талаар аймгийн Засаг даргын 1/668 дугаар албан бичиг хүргүүлэн хэрэгжүүлж байна.

Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоотой 2012-2019 оны хооронд орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, бодлого, арга хэмжээний үр дүнгийн талаарх судалгааг сумдаар гаргуулан нэгтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

Ховд аймгийн 2020 оны 1 дүгээр улирлын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулахаар аймгийн хэмжээнд “SMS” үйлчилгээг нэвтрүүлж төсвийн захирагч, нягтлан бодогч нарт сар бүр мессежээр чиглэл хүргүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаандаа бүрэн оруулахыг анхааруулан ажиллаж, 2020 оны 04 дүгээр сарын 14-ны байдлаар аймгийн хэмжээнд нийт 17 сум, 152 байгууллагын 7044 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 5849 мэдээллийг байршуулсан, нийт байршуулсан 5849 мэдээллийн 5237 мэдээлэл хуулийн хугацаандаа, 612 мэдээлэл хугацаа хоцорсон шилэн дансны мэдээллээ байршуулсан дундаж үзүүлэлт 83 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны 1 дүгээр улирлын урьдчилсан гүйцэтгэлд судалгаа, шинжилгээ хийж цаашид анхаарах асуудлын чиглэлийг гарган танилцуулга бичиж боршрут ном болгон 10 хувь олшруулж аймгийн удирдлагуудад хүргүүлэв.


Аймгийн аж ахуйн нэгжүүдийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг шалган хүлээн авах ажлын арга зүйн мэдээлэл, зар сурталчилгааг нийт аж ахуйн нэгжүүдэд цахим болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хүргэж Е баланс программаар цахим хэлбэрээр авч баталгаажуулан нэгтгэл хийлээ. Аймагт 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тушаах 1814 аж ахуйн нэгжээс 1546 буюу 85.2 хувь нь тайлангаа программд илгээснийг хүлээн авч нэгтгэлээ. Тайлан илгээсэн аж ахуйн нэгжийн тоо өмнөх оноос 60 аж ахуйн нэгжээр буурсан байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар аймагт Үнэт цаасны компани 1, Банк бус санхүүгийн байгууллага 1, Хадгаламж зээлийн хоршоо 6, Төрийн бус байгууллага 85, хоршоо 174, ХХК 1279 нийт 1546 аж ахуйн нэгж байгууллагууд тайлангаа цахим системд илгээсэн ба эдгээр байгууллагуудын тайланг хүлээн авч баталгаажууллаа.

Зураг 1 /Тайлан баталгаажуулалт-хувь/



Зураг 2 /Тайлан баталгаажуулалт-тоо/



Жилийн эцсийн тайлан авахдаа хуулийн дагуу аудитын байгууллагаар баталгаажуулах шаардлагатай 187 тайланг 21 аудитын компаниудаар баталгаажуулж нэгтгэлээ.

Ховд аймгийн нийт аж ахуйн нэгжүүд нэгдсэн дүнгээр 2019 оны санхүүгийн тайлангаар борлуулалтын үндсэн орлого 335898.9 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны болон хүүгийн бус орлого 1104.0 сая төгрөг нийт 337002.9 сая төгрөгийн борлуулалт, ажил үйлчилгээ үзүүлсэн бөгөөд борлуулсан бүтээгдэхүүний зардалд 282059.4 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 48047.9 сая төгрөг, бусад зардалд 4316.2 сая төгрөг нийт 334423.5 сая төгрөгийн зардал гарч 2579,4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллажээ. Улсын төсөвт орлогын албан татвараар 572.6 сая төгрөг төлөх ногдуулалт хийж татвар төлөлтийн дараах ашиг 2006.8 сая төгрөг байна.

Өмнөх оноос орлого 129632,8 сая төгрөгөөр, зарлага 118856,2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 3 /Борлуулалтын орлогын харьцуулалт/



Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 3-4 дүгээр сард Ховд сумын төсөвт байгууллагууд, Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэг, Эрдэнэбүрэн сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. Ховд суманд хийсэн шалгалтаар сумын хэмжээнд 247 хүнтэй холбоотой 35,3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 27,7 сая төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар 7,6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар тус тус шийдвэрлэж, улсын байцаагчийн 29 акт бичсэн.

Төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн албаны дарга нар төсвийн байгууллагуудын гүйлгээ хийхдээ төрийн сангийн хяналтыг хууль эрх зүйн хүрээнд тавиагүй, анхан шатны баримт байхгүй, бүрдээгүй тохиолдолд гүйлгээ хийдэг, Төсвийн тухай хууль зөрчсөн гүйлгээг хийсэн зэрэг нь төрийн сангийн хяналт хангалтгүй, сул байгааг харуулж байна.

Жаргалант сумын 15 дугаар цэцэрлэгт хийсэн хяналт шалгалтаар нийт 21,6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,6 сая төгрөгийг улсын байцаагчийн актаар төлүүлэхээр 20,1 сая төгрөгийг хугацаатай үүрэг арилгахаар шийдвэрлэлээ.

Үенч сумын сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой Авлигатай тэмцэх газарт ирсэн өргөдөл гомдлын дагуу хяналт шалгалт хийж, 2020 оны 04 сарын 27-ны өдрийн 70 дугаар албан бичгээр хариуг хүргүүллээ. Мөн Эвийн хүч хоршоо, Мянган угалзат ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой хяналт хийх ажлын хэсгүүдэд аймгийн Засаг даргын болон аймгийн ИТХ-ын даргын захирамжаар тус албанаас 2 байцаагч ажиллаж дүн мэдээг хүргүүллээ.

Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгын ажлын техник хяналтын зардлын орлого зарцуулалтын талаар судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт саналыг Сангийн яаманд хүргүүллээ.

Статистикийн хэлтсийн салбар хариуцсан мэргэжилтэнүүд 2020 оны 1 дүгээр улирлын мэдээг 300 гаруй аж ахуйн нэгжээс салбарын мэдээний маягтаар цуглуулж программд шивж Үндэсний статистикийн хороонд 4 дүгээр сарын 4-21-нд графикт хугацаанд бүрэн дамжууллаа.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа Жаргалант сумын Буянт, Рашаант багт, Дуут сумын Босго, Ховд сумын Баруунсалаа, Булган сумын Баянсудал, Мөнххайрхан сумын Сэнхэр багуудад хийгдэж, ажиллах хүчний судалгаа Жаргалант сумын Буянт, Мянгад сумын Баянхошуу, Цэцэг сумын Цэцэгнуур, Зэрэг сумын Бургасан багуудад судалгааны ажил хийгдэж байна.

**Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:**

**Шүүхийн шинжилгээний алба:** 2019-2020 оны сургалтын хөтөлбөр гаргаж, төлөвлөгөөний дагуу 2 сэдвээр 2 цагийн сургалт зохион байгууллаа. Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим [khovd\\_nifs@yahoo.gov](mailto:khovd_nifs@yahoo.gov) хаягаар хүлээн авч ажиллаж байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 6 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 81, эд эсийн шинжилгээ 6, тусгай шинжилгээ 31, 11 криминалистикийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргасан. Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 58 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 34 ширхэг мөр, гутлын мөр 38, тээврийн хэрэгслийн мөр 33, биологийн гаралтай ул мөр 6, 63 бусад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 18, 31 гарын мөр авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийж ажиллав.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээний дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд оруулав.

**Цагдаагийн газар:** Тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд: Улсын хэмжээнд явагдаж байгаа “Байгалиа хамгаалъя”, “Ачааны автомашин-Ачаа тээвэрлэлт” зэрэг нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Захирамж”, “Шатахуун түгээх станц” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд үйлчилгээний байгууллагын цагийн хуваарь болон үйл ажиллагааг нь түр хугацаагаар хориглох зэрэг цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Цагдаагийн газрын нийт алба хаагчид нэмэлтээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж баар ресторан, дэлгүүр, архи согтууруулах ундаа худалдан борлуулах үйлчилгээ үзүүлдэг давхардсан тоогоор 284 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, 31 зөрчил илрүүлж холбогдох хууль



тогтоомжоор шийтгэл оногдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор яриа таниулга хийж 300 санамж, сэрэмжлүүлгийг facebook цахим хуудсанд байршуулан орон нутгийн Ховд, Жаргалант телевизээр иргэд олон мэдээлэв.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд баривчлагдсан 41 этгээдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрт 2 цагийн албадан сургалтыг 15 удаа зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран архины хамааралтай гэр бүлийн хүчирхийлэл 1 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан.

Орон нутгийн “Ховд”, “Олон ястны” телевиз, “Гэр бүлийн радио” FM104, Тэмүүлэл FM 89.1-тэй хамтран байгууллагын үйл ажиллагаа болон улс, орон нутгийн хэмжээнд зохион явуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг 1, зочны буюу ярилцах цаг 2, 10 мэдээ сурвалжлагыг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, “Khovd.mn”, “Монцамэ”, “Khovdnews.mn” сайтад 4 удаагийн ярилцлага, мэдээлэл нийтлүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2020 оны 3 дугаар сарын 25-аас 4 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 237 гомдол мэдээлэл хүлээн авсны 94 буюу 39,7 хувийг гэмт хэргийн шинжтэй, 143 буюу 60,3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн 49 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 4, Хулгайлах гэмт хэрэг 6, Мал хулгайлах 2, Залилах гэмт хэрэг 4, Эд хөрөнгө устгах, гэмтээх 1, Завших 3, Авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 4, Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 10, Авто тээврийн хэрэгслийн зөвшөөрөлгүй авч явах 2, Хууль бусаар мод бэлтгэх 1, Чанар муутай барилга, байгууламж ашиглалтанд оруулах 1, Дээрэмдэх 1, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох 1, Худал мэдээлэл тараах 1, Хууль сахиулагчийг эсэргүүцэх 1 хэрэг тус тус бүртгэгдсэн.

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусдын биед халдах 9, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 13, Залилах 5, Зам тээврийн осол 10, ЗХАБЖЗ 2, Мал хулгайлах 11, ОНАТБА 17, Завших 16, Хулгайлах 6, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг 1, Дээрэмдэх 2, Татвар төлөхөөс зайлсхийх 1, Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 14, Хууль сахиулагчийг эсэргүүцэх 3, Хүрээлэн байгаа орчны эсрэг 12, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1, Худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 17, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 4, Хүний бэлшийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 1, Цахим-Компьютр мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 2, Хууль бусаар ашигт малтмал хайх олборлох 5, Цэргийн албаны эсрэг 1, Хүчиндэх 3 гомдол мэдээлэл тус тус хүлээн авсан байна.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 106 хүнийг эрүүлжүүлж, 214 хүнийг 43,045,000 мянган төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 55 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 41 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж шийтгэл оногдууллаа.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс нь тайлант сард нийт 2740 иргэнд үйлчилгээ үзүүлж, Үүнээс: аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд байхгүй, шилжин ирсэн иргэд байхгүй, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн иргэд байхгүй гадаад паспорт олголт 60, иргэний үнэмлэх шинээр олгосон 159, сунгалт 296, 87 иргэнд паспорт дахин олгож ажиллав.

Иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлээр нийт 304 иргэнд үйлчлэв. Үүнээс: Төрөлт 196, үрчлэлт 3, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 11, эцэг тогтоолт 12, гэрлэлт 26, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 3, нас барсны бүртгэл 31, нөхөн бүртгэл 17, регистр олголт 5, 1106 иргэнд лавлагаа олгож ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 560, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 153 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав. Иргэдээс нийт 15 өргөдөл, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд 8 шийдвэрлэж, 1 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж, 6 өргөдлийн хугацаа болоогүй шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

**Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** Монгол Улсын засгийн газар, БСШУСЯ, аймгийн Засаг даргын хөтөлбөрийг удирдлага болгон Боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

БСШУСЯ-аас зохион байгуулж буй ТВ цахим хичээлийг мэргэжлийн группд байршуулан тухай бүр хүргэж байна. Мөн ТВ цахим хичээлийг үзэж байгаа талаарх тоон судалгааг Цаст-Алтай, Прогресс, 7 дугаар сургууль, лицей сургуулиас 7 хоног бүр авч нэгтгэхэд тайлант сард теле хичээлийн хамралтын дундаж СӨБ 57,9, ЕБС-57,6 хувьтай байна.

Төгсөх ангийн сурагчдын ЭЕШ-ын бэлтгэлийг эрчимжүүлэх, урьдчилан түвшин тогтоох, цаашдын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор авах "Их сорил 4"-ын сэдвийг боловсруулж, цахим сорил 3-ыг 4 дүгээр сарын 6-ны өдөр элсэлтийн шалгалтын журмын дагуу 80 минутаар зохион байгуулахад ирц оролцоо аймгийн төвийн 62 /-17/, хөдөөгийн 85 /-25/, нийт 147 /-42/ сурагч хамрагдаж, дундаж гүйцэтгэл 58.9 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх сорил 2-оос 1,5 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Цахим сорил 4-ийг 4 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулахад ирц оролцоо аймгийн төвийн 68 /+6/, хөдөөгийн 101 /+16/, нийт 169 /+22/ сурагч хамрагдаж, дундаж гүйцэтгэл 52.9 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх сорил 3-аас 6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Этүгэн их сургуулиас 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж буй "Миний мэдэх Этүгэн их сургууль"эсээ бичлэг, 12 дугаар ангийн сурагчдын дунд



зохион байгуулж буй Математик, Биологи, Хими, Физик, Англи хэл, Нийгмийн тухай мэдлэг зэрэг хичээлийн цахим сорилгын уралдааны удирдамж чиглэлийг бүх сургуулиудад хүргүүлж, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар facebook хаягаар олон нийтэд мэдээллийг хүргэлээ.

Сургуулийн өмнөх боловсролын Теле хичээлд аймгийн хэмжээнд 5969 хүүхэд хамрагдахаас тайлант сард хамрагдалт 76,8 хувьтай байгаа нь өмнөх саруудаас 57,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Учир нь хүүхдүүд хөдөө өвөө, эмээрүүгээ явсан энэ талаар цэцэрлэгийн эрхлэгч нарт чиглэл хүргүүлж ангийн групп чатаар дамжуулан хүүхдийн оролцоог нэмэгдүүлж идэвхжүүлэх, сонирхолтой даалгавар зөвлөгөө мэдээлэл оруулах ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Аймгийн Онцгой байдлын шийдвэрээр цэцэрлэгийн бүх багш ажилчид ээлжийн хуваарийн дагуу 5000 гаруй хүүхэд, иргэдэд 700 гаруй олноор цугласан газарт, зөвлөгөө мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Covid-19 цар тахлын үед Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх тухай 3 яамны хамтарсан төлөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах чиглэл бүрээр төлөвлөгөө гаргаж сургууль цэцэрлэгт хүргэж тайланг нэгтгээд байна.

Соёл урлагийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын судалгааг нэгтгэж холбогдох байгууллагуудад хүргүүлж, БСШУСЯ-нд боловсрол, соёл, урлагийн газрын үндсэн үүргийн судалгааг гарган, саналыг тусгаж, Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны ЮНЕСКО-ийн тайланг маягтын дагуу нэгтгэж судалгааг гаргаж байна.

Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд гудамжны самбарын мэдээллийг ДЗОУ байгууллагын дэмжлэгтэйгээр **“Зөв аав, ээжийн энгийн дүрэм”** мэдээллийг байрлуулаа. Гэр бүлийн орчинд хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангах, аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/115, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/71, Эрүүл мэндийн сайдын А/155 тоот хамтарсан тушаалаар 03-р сарын 15-ны өдрөөс 4-р сарын 01-ний өдрүүдэд "Хүүхэд эрхэм хэрэглэгч" аян үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан: Энэхүү аяны хүрээнд аймгийн БСУГ-аас "Миний гэр аюулгүй орчин" хяналтын хуудсыг **Google Form** ашиглан сургууль цэцэрлэг эцэг эхчүүдээс цахим судалгаа авлаа. Судалгаанд нийт 2447 хүн хамрагдаж, нийт хамрагдагдсан иргэдийн 58% боловсролын салбарын ажилтан, 42% орчим нь эцэг эхчүүд хамрагдсан байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд өрх толгойлсон 2 хүүхэдтэй эхийг холбон зуучилж хамгааллын үйлчилгээнд хамрууллаа.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал буюу шинэ корона вирусын /Covid 19/ халдвар дэгдсэнтэй холбоотойгоор аймгийн онцгой комиссын хурлыг 3 удаа, шуурхай штабын хурлыг 9 удаа хийж, цаг үеийн мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж, 25 арга хэмжээг шийдвэрлэж хариу арга хэмжээ авч ажиллав.

Зам тээврийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг Булган боомтын нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдон бэлэн байдалд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, олон нийтийн дунд COVID-19 халдвараас аймгийн онцгой комиссын шийдвэрээр “Маскаа зүүцгээе” аяныг 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, хөдөлгөөнт эргүүлийг байгууллага бүрээр өдрийн хуваариар ажиллуулан иргэд олон нийтэд сурталчилгаа хийлгэж, нийтийн эзэмшлийн болон байгууллагуудад нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэлээ.

Мөн халдварын бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Ховд Их сургууль, Хөдөлмөр политехник коллеж, төвийн Ерөнхий боловсролын YII сургуулийн дотуур байранд 1000 орчим иргэдийн ажиглалтын байр, ор бүхий 5 эмнэлэгүүдэд халдварласан иргэдийн эмчлэх 80 орыг бэлэн байлгах гэрээг тус тус байгуулан, халдвартын тасгийн дэлгэсэн өрөө тасалгааны байдалд давтан хяналт хийж, подвалийн хэсгийг цэвэрлүүлж халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Мөн улсын онцгой комиссоос ирүүлсэн үүрэг чиглэл, аймгийн онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд 15 000 маскийг 3 аж ахуйн нэгж, компанитай гэрээ хийж нөөцийг бүрдүүлээ.

Эрүүл мэндийн яам Халдвар судлалын үндэсний төвд санал хүргүүлж Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вируслогийн лабораторид COVID-19 халдварын 100 ширхэг оношлуур авч нөөцөллөө.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Тусгаарлан ажиглах байранд байх хугацаанд хог хаягдлыг ангилах, тээвэрлэх, устгах зааварчилгаа”, “COVID 19” үед хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх заавар”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 143 дугаар тушаалаар өгөгдсөн халдваргүйтгэл, ариутгал, шавжгүйтгэлийн бодисын “Жагсаалт батлах тухай” зэрэг эрх зүйн акт, заавруудыг хүргүүлж, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэргэжилтэн аймгийн төвд ажиллаж “COVID 19”-ийн талаар аймаг орон нутгийн зүгээс авч хэрэгжүүлж буй байдалтай танилцан шаардлагатай зөвлөмжийг өгч, тус халдварын үед ажиллах нийт 75 эмч мэргэжилтэнг сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулснаар халдварын үед ажиллах эмч мэргэжилтэн чадавхижиж тусламж үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх боломж дээшиллээ.

Тайлант сард заавал хийх дархлаажуулалтын 3 сарын хамралт болон зарцуулалтын мэдээг БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн ХӨСҮТ-д хүргүүлж 3 сард 0-2 насны хүүхдийг 100 хувь дархлаажуулалтанд хамруулж “Дархлаажуулалтанд хамрагдсан тухай лавлагаа, мэдээлэл авах иргэд, үйлчлүүлэгчдийг харъяа эрүүл мэндийн байгууллагаас нь зааврын дагуу гарган өгч ажиллах тухай” аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 348 дугаар албан тоот бичгийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж ажиллалаа.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд Ховд сумын эрүүл мэндийн төвийн хөргөгч, аймгийн вакцины агуулахын хөргөгчийн хангалт

дутмаг байгаа талаар мэдээлэл, албан тоот өгч Ховд аймагт нэг бүрийн үнэ 4,197,100 төгрөгийн өртөг бүхий Vestfrost VLS -064A маркийн мөсөн ханатай хөргөгч 3, дагалдах хэрэгслийн хамт авч, Ховд сумын Эрүүл мэндийн төв, Рашаант өрхийн эрүүл мэндийн төвд хуваарилж 4 дүгээр сард анхан шатны нэгжүүдэд нийт 21 удаа вакцин, биобэлдмэл хүргүүлж ажилласан.

Эрүүл мэндийн салбарын бусад төлөвлөсөн ажил хугацаандаа хийгдэж байгаа бөгөөд төлөвлөлтөнд тусгагдсан сумдын иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах графикт ажил нөхцөл байдалтай холбоотойгоор тасарч хойшлогдоод байна.

**Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:** Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд 2020 оны 04 сарын 24-ны байдлаар ажил хайгч иргэд 1770 үүнээс 886 эмэгтэйчүүд байна. Тайлант сард нийт 21 иргэнийг шинээр бүртгэж, идэвхигүй жагсаалтанд байсан 368 иргэний мэдээллийг шинэчилж шинээр бий болсон 251 ажлын байрыг бүртгэв. Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 384 ажлын байрны захиалга авч, 335 иргэнийг ажлын байранд зуучиллаа. Байнгын ажлын байранд 147, улирлын ажлын байранд 94, түр ажлын байранд 94 иргэнийг ажилд зуучилсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд 59 ажил хайгч залуучуудад ганцаарчилсан зөвлөгөө өгч, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийг 16 иргэнд утсаар өгч, сул чөлөөтэй ажлын байрны танилцуулга, ажил хайгч иргэдийн мэдээллийг шинэчлэн бүртгэв.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах залуу малчдыг сонгон шалгаруулах арга хэмжээг хөдөөгийн 16 суманд зохион байгуулж, нийт 53 малчин өрхөд 245,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 40 иргэн төсөл ирүүлснээс 26 хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжиж 57,0 сая, ахмад настан хувиараа хөдөлмөр эрхлэгч 32 иргэн төсөл ирүүлснээс 17 ахмадыг 25,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олгохоор шийдвэрлэж, нийт 46 иргэнд дэмжлэг үзүүллээ.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд эрүүл мэндийн салбарын ахмад мэргэжилтнүүд хамрагдаж, Жаргалант сумын 12 багийн нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан нийт 72 иргэн зөвлөгөө мэдээлэл, тусламж үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 117 иргэн төсөл ирүүлснээс шаардлага хангасан 71 иргэний төслийг дэмжиж 194,0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. Төсөл нь батлагдсан иргэдтэй гэрээ хийж, эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг олголоо.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 22 төсөл ирүүлснээс 17 төслийг дэмжиж 180 иргэнийг түр ажлын байраар ханган 61,6 сая төгрөгийн цалин олгохоор шийдвэрлэж, хамтран ажиллах гэрээгээр ажиллаж байна.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 17 сумын 17 бүлгийн 77 өрх хамрагдаж байна. Орон нутгийн төсвөөс Нийгмийн халамжийн санд 60 000 000 төгрөг, Улсын төсвөөс Ахмад дайчин алдар цолтон ахмадад 45.000.000 төгрөг, Алдарт эхийн одонд 1.212.100.000 төгрөг, Ахмад настны насны хишигт 282.330.000 төгрөг, Цалинтай ээж хөтөлбөрт 775.000.000 төгрөг, Халамжийн тэтгэвэрт 1.169.996.950 төгрөг, Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрт 97.040.000 төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжид 512.000.000 төгрөг, Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид 231.716.000 төгрөг, Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжид 270.696.000, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт тусламжид 126.082.000 төгрөг, Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжид 135.000.000 төгрөг, Хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид 456.420.000 төгрөг, Нийт 5.373.380.950 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагаа хэвийн явж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд нийт 1614 өрхийн 48171 том хүн, 4244 хүүхэд хамрагдаж 111,888,000 төгрөгийг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2020.04.15, 22-ны өдрүүдэд хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 28 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа. Хуулийн дагуу ортопедийн тусгай хэрэгсэл авах хүсэлтэй 16 иргэний бичиг баримтыг хүлээн авч 34 ширхэг ортопедийн туслах хэрэгсэл олгож waic программд бүртгэлээ.

Өрхийн хөгжил, зорилтот өрхийн хөгжил хамгааллын чиглэлээр “Хөгжилд хүргэе” хөтөлбөрт хамрагдсан 6 иргэний төслийг хүлээн авч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ажилгүй иргэдийн бүртгэлд 7 иргэнийг холбон зуучиллаа. Мөн Дэлхийн зөн орон нутгийн хөтөлбөртэй хамтарч “Цар тахал хэмээн зарласан COVID-19-д өртөх хамгийн өндөр эрсдэлтэй өрхөд туслах” чиглэлээр бага насны олон хүүхэдтэй зорилтот бүлгийн 5 өрхөд хүнсний тусламж олгож, санхүүгийн дэмжлэгт зорилтот бүлгийн 2 өрхөд тус бүр 100 долларын дэмжлэг үзүүллээ.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 633 даатгуулагчийн 176926.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалд 4412 даатгуулагчийн 181781.6 сая төгрөгийн орлого, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 803 ажил олгогчийн 12154 даатгуулагчийг хамруулж нийгмийн даатгалын санд 2684215.3 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Үүнд: Өндөр насны тэтгэвэр авагч 7868 иргэнд 12658929.6 сая тахир дутуугийн тэтгэвэр авагч 1728 иргэнд 3011043.9 сая тэжээгчээ алдасны тэтгэвэр авагч 690 иргэнд 1138001.3 сая цэргийн алба хаасны тэтгэвэр авдаг 295 иргэнд 763628.9 сая, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тахир дутуугийн тэтгэвэр авагч 35 иргэнд 60112.1 сая төгрөгийн тэтгэвэр тус тус олголоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 456 даатгуулагчид 622305.3 сая төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 257 даатгуулагчид 295477.0

сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 406 даатгуулагчийн 142971.8 сая төгрөг, 106 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 106 сая төгрөг тус тус зарцуулсан.

ЭХМК-с нь тайлант сард 2 удаа хуралдаж нийтдээ 135 иргэний ХЧА-н асуудал хэлэлцэн шийдвэрлэж 31 иргэнд шинээр ХЧА-т тогтож, 1 иргэн шилжиж ирсэн, 89-иргэний ХЧА-ыг сунгаж, 14 иргэний ХЧА-г цуцалж, мэдээллийн баазад 3052 иргэн бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд насанд хүрэгч 27, хүүхэд 8, нийт 35 үйлчлүүлэгч сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан ба 4 үйлчлүүлэгч давтан зөвлөгөөнд хамрагдлаа. Зөвлөгөөнд хамрагдсан болон хамрагдаж буй иргэдийн сэтгэл зүйн байдал тогтворжин учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэхээс гадна тулгамдсан асуудлаа даван туулж байна. Шалтгаанаар нь авч үзвэл гэр бүлийн харилцааны зөрчлийн асуудлаар – 9, бэлгийн хүчирхийллийн хохирогч 1, сэтгэл гутрал стрессийн асуудлаар – 8 үйлчлүүлэгч хамрагдсан байна.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:** Дэлхийн зөн Ховд ОНХ-ийн хүрээнд дэмжлэг туслалцаа шаардлагатай 680 өрхөөс 280 өрхийн судалгааг гаргаж 100 ам долларын мөнгөн дэмжлэгийг олголоо. Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын ерөнхий төлөвлөгөөг хангах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд нэн шаардлагатай 680 эрсдэлтэй өрх, гэр бүлийн зураглалыг гаргаж түргэвчилсэн үнэлгээ хийлээ.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 19, бичгээр 12 өргөдөл, гомдол нийт 31 дуудлага мэдээлэл ирсэн тул нөхцөл байдлын үнэлгээ хийж хариу үйлчилгээ үзүүлж, сумдын хамтарсан баг, холбогдох байгууллагуудад 16 кейс холбон зуучилсан. Нийт гомдол мэдээллийг хэлбэрээр авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 12, бэлгийн хүчирхийлэл 3, гэмт хэрэгт холбогдсон 2, бие мах бодийн 3, сэтгэл санааны 4, эдийн засгийн 2, үл хайхрах хүчирхийлэл 4 үйлдэгдсэн, орчноор авч үзвэл олон нийтийн орчинд 2, боловсролын орчинд 1, гэр бүлийн орчинд 28 байна.

Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөтөлбөртэй хамтран “Өөрийгөө болон бусдыг өвдхөөс сэргийлж гараа угаацгаая”, “Ханиаж найтаахад анхаарах зүйлс” “Шинэ корона вирусийн халдвараас сэргийлье”, “Шинэ корона вирусийн халдвараас хамгаалах аргууд”, “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж” маск зүүх, гараа сайн угаах нь коронавирусаас өөрийгөө болон гэр бүл, найз нөхдөө хамгаалах хамгийн зөв арга болох талаарх зөвлөмжийг олон нийтэд хүргэлээ.

Хүүхэд хамгааллын эргүүлийн баг ээлжит хугацааны болон аймгийн шуурхай штабаас гаргасан хуваарийн дагуу Жаргалант сумын Бичигт, Баатархайрхан, Тахилт, Алагтолгой, Хайрхан, Бугат, Буянт, Магсаржав, Жаргалан багийн нутаг дэвсгэрийн нийт 18 цэгт хяналт тавьж ажиллав. Эрсдэлд өртөж болзошгүй БОЭТ-ийн хүүхдийн тасаг, яаралтай түргэн тусламжийнхан, Хот тохижуулах газрын үйлчилгээний ажилтан албан хаагчид зарим СӨХ-ийн ажилчид болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд,



залуус, гэр бүл, иргэдэд бактерийн эсрэг багц саван, гарын авлага, сурталчилгааны материал зэргийг тарааж сэрэмжлүүлэг, уриалга, зөвлөгөө, мэдээллийг ард иргэдэд хүргэлээ.

Дуут суманд 2020 оны 04 сарын 01-ний өдөр хурдан морины бооцоот уралдаан, үсэргээ, сунгаа болж, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах арга хэмжээ зохион байгуулагдсан гэх Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн дагуу шалгах ажиллагаа явуулж 5 уяачид Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.3-д зааснаар тус бүр 500.000 төгрөгөөр торгох шийтгэлийг хялбаршуулсан журмаар оногдуулж шийдвэрлэв.

**Тав: Сумдын мэдээлэл:**

**Жаргалант сум:** "Маскаа зүүцгээе" аяны хүрээнд хүн ам олноор үйлчлүүлдэг газруудад 3 удаагийн хяналт шалгалт хийж иргэдийг амны хаалт зүүх үйл ажиллагааг идэвхжүүлэх, уриалах, Covid-19 вирусын цар тархалтаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг тарааж ажиллалаа.

Олон нийт Цагдаагийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, covid-19 вирусын цар тархалтаас урьдчилан сэргийлэх зорилготой төрийн байгууллагын албан хаагчдыг хамарсан эргүүлийг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулж 9 байгууллагын албан хаагчид эргүүлийн үйл ажиллагааг Цагдаагийн албан хаагчидтай хамтран гүйцэтгээд байна.

Жаргалант сумын Засаг даргын А/120 дугаар захирамжийн дагуу сумын нутаг дэвсгэрт эзэн харъяагүй 76 мал амьтны сэг зэмийг 47.980242, 91.671309 устгалын цэгт ачиж төвлөрүүлж, кг 1:200, хлорын шохойн 2%-н уусмал ашиглан цацаж халдваргүйжүүлээ. Хашаа, хороо, өтөг бууц, худаг уст цэгийн 1090 /м2/ талбайд халдваргүйжүүлэлт хийгээд байна. Сумын хэмжээнд 45638 мал төллөхөөс 42583 төл бойжуулж, мал төллөлт 94 хувьтай байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/125 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Ховд хотод үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжүүд 14 хоног тутам хуваарийн дагуу цэвэрлэгээний ажлыг 2 удаа зохион байгуулж 26 байгууллагын 250 гаруй ажилтан албан хаагчид, 12 багийн иргэд оролцож 36м<sup>3</sup> хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт хүргээд байна.

Сумын Засаг даргын А/120 дугаар захирамжаар ариутгал халдваргүйжүүлэлтийн аян зохион байгуулж 12 багийн 780м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж 4 машин үхсэн мал амьтны сэг зэмийг цэвэрлэж устгах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сумын Засаг даргын А/129 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлыг хэсэг Ховд хотын ногоон байгууламжийн тооллого хэмжилтийн ажил зохион байгуулав. Энэхүү тооллогоор хотын нийтийн эзэмшлийн талбайд нийт 250 тагт, сааданд хайлаас 491, шилмүүст мод 15, шар хуайс 187, улиас 160, бургас 5, агч 7, нохойн хошуу 1, зэгд 2, бусад 504 нийт 1372 мод тооллогдож бүртгэгдэв.



“Хотын төвийн ногоон байгууламжийн ажлын талаар авах арга хэмжээний тухай” захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй цэцгийн мандлуудыг хариуцах хамтран ажиллах гэрээ байгуулан ажилллаж нийт 250 цэцгийн мандалыг 67 албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хариуцууллаа.

Сумын оёдол, хүнсний ногоо, чацаргана тариалах, зоорь барих зэрэг 5 иргэний төслийг сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжиж Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт уламжилсан

Сумын амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай зорилтот бүлгийн 32 иргэдэд замын зардал, асаргааны тэтгэмж 10, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 4 өрхийг хамруулав.

Дэлхийн Зөн Ховд ОНХХ-ийн газрын санхүүжилтээр аймаг, сумын Засаг даргын Тамгын газар хамтран сумын 208 өрхөд 100 долларын тусламж өгөхөөр ажлын хэсэг байгуулан айл, өрхийн судалгааг гаргаж өрхүүдийг бүрэн хамруулад байна.

**Мөст сум:** Халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн хүрээнд худалдааны дэлгүүр түцүүдийн ажлын хуваарийг багасган архи, согтууруулах ундааг борлуулахыг хориглож тоглоомын газруудын үйл ажиллагааг хаав. Энэ ажлын хүрээнд бүх дэлгүүр түцний үйл ажиллагаанд хяналт тавьж архи, согтууруулах ундааг тоолж лацдан хяналтын тооллогыг 2 удаа хийлээ.

Сумын гудамж талбай, аж ахуйн нэгж, албан байгууллагын гадна орчинд ариутгал халдаргүйтгэл тогтмол хийж байна

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 2 даатгуулагч хамрагдсан, нийт 39 даатгуулагчийн 1474.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 15 даатгуулагчийн 624.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 3 байгууллагын 7978.9 мянган төгрөг, нийт 8747.6 мянган төгрөгийн орлого орж нийт орлогын төлөвлөгөө 89 хувьтай хэрэгжиж байна.

Нийгмийн даатгалын сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 160718,5 мянган төгрөг, 1 төрлийн тэтгэмжинд 1800.6 мянган төгрөг, нийт 162519.1 мянган төгрөг олгосон ба тайлант сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 7 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 5 даатгуулагч тэтгэвэрээ тогтоолгов.

**Эрдэнэбүрэн сум:** Сумын төвийн ногоон байгууламжийн услалтыг нэмэгдүүлэх зорилгоор Буянт стандарт ХХК-ийн гүйцэтгэлээр улаан богоч орчмын 300м усны шуудууг далан үүсгэн өргөтгөн, 400м усны шуудууг бетон болон чулуугаар доторлолоо. Мөн 1500м шуудууг дахин өргөтгөж сэргээн засварлав.

Аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт албан бичиг хүргүүлж нийтийг хамарсан ажилд сумын ажилгүй иргэдээс 10 хүнийг 10 өдрийн хугацаанд ажиллуулан сумын төвийн орчны цэвэрлэгээг хийж, цэвэр орчин бүрдүүлэх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, услалт, хамгаалалтыг сайжруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.

Загасны үржлийн үед Шижигтийн хавцалд БОХ-ын байцаагч, байгаль хамгаалагчид, сумын цагдаа, олон нийтийн цагдаа, ТХГН-ийн байцаагч нар хуваарийн дагуу хяналт хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд нийт 500 гаруй хүн, 120 орчим машин техник бүртгэгдсэн байна.

Зэрлэг нүүдлийн шувууны дунд томуу болон вирусын гаралтай халдвар өвчний тандалт хоёр удаа хийсэн. Малчид иргэдэд заавар, зөвлөгөө болон шувууны томуу өвчнөөс хэрхэн сэргийлэх заавар зөвлөмж, гарын авлага, материал тарааж ажилласан. Шувуу ихээр ирж байршдаг Хиймэл нуур, Их арал, Галуу төрдөг арал, Жоншоон, Бор модны арал болон Ховдын голын сав газраар хяналт тандалт хийхэд 10 орчим зүйлийн 650 орчим нүүдлийн шувуу байгаа нь ажиглагдаж тэмдэглэлээ.